



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2023/86/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх
аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: П.Чанцалдулам
Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulam@audit.gov.mn
Ахлах аудитор: И.Эрдэнэцэцэг
Утас: 261628 Цахим хаяг: erdenetsetseg@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн
"Сүлд-Аудит" ХХК-ийн захирал: Ч.Гүндбаяр
Утас: 70118016 Цахим хаяг: info@suld-audit.mn

Улаанбаатар хот
2023 он



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2023.03.21 № 07/627
танай _____-ны № _____-т

Г Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа, зөрчил нь тогтоосон 179.9 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 заалтыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, иж бүрэн байх, нийцтэй бөгөөд зохистой, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Тайлант жилийн орлогоо аккурэл сууриар бүртгээгүй;
- Санхүүгийн тайланд тайлагнагдсан 3,061.8 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй;
- Бусад санхүүгийн хөрөнгө дансанд бүртгэлтэй мөнгөн хадгаламж 3,430.4 сая төгрөгийг тайланд онд ТУЗ-ийн шийдвэргүйгээр үйл ажиллагаанд зарцуулсан, шинээр 1,500.0 сая төгрөгийн хадгаламж нэмж байршуулсан;
- Тайлант оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлан болон НӨАТ-ын тайлангаарх орлогыг тулган шалгахад 323.1 сая төгрөгийн зөрүүтэй, мөн тайлант онд бүртгэсэн орлогоос 59.1 сая төгрөгийн борлуулалтын орлогыг нотлох баримтгүйгээр орлого бууруулах бичилт хийсэн;
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар 2,142.1 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Монголын цахилгаан холбоо ХК нь нийт 25,870,276 ширхэг энгийн хувьцаатай, үүнээс 94.7 хувь буюу 24,499,287 ширхэг хувьцааг Монгол Улсын Засгийн Газар, 5.3 хувь буюу 1,370,989 ширхэг хувьцааг гадаад дотоодын иргэд, хуулийн этгээд эзэмшдэг нээлттэй хувьцаат компани бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нэгж хувьцааны хаалтын ханш 659.6 төгрөг, зах зээлийн үнэлгээ 17,064.0 сая төгрөг байсан байна.

Монголын цахилгаан холбоо ХК нь нийт хувьцааны 34 хүртэлх хувь буюу 11,249,856 ширхэг хувьцааг нэмж гарган, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон Санхүүгийн зохицуулах хорооноос ирүүлсэн чиглэл, зөвлөмжийн дагуу нэмэлт хувьцааг биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй худалдах бэлтгэл ажлын төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлөөрөө батлуулан ажиллаж байна.

Аудитын гол асуудал

ТУЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн 2022 оны нийт орлогыг 19,458.8 сая төгрөгөөр, нийт зардлыг 19,410.7 сая төгрөгөөр, 48.1 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай байхаар эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөг баталсан. Гүйцэтгэлээр 18,814.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 18,779.1 сая төгрөгийн зардал гарган, 34.1 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 79 зорилтын хүрээнд 214 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



Z:\Yawsan_Bichig\2023\0315 SNAG-61.Docx

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	983,774,286.87	308,008,601.51
1.1.2	Дансны авлага	1,630,966,303.91	2,376,672,393.18
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	107,439,188.81	5,823,290.88
1.1.4	Бусад авлага	1,009,876,449.41	1,494,072,787.88
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	3,430,407,416.08	1,500,000,000.00
1.1.6	Бараа материал	2,701,204,154.66	3,216,553,507.21
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	1,703,703,940.89	472,470,179.60
1.1.10	Эргэлтийн хөрөнгийн дүн	11,567,371,740.63	9,373,600,760.26
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	22,204,400,547.93	26,224,751,163.31
1.2.2	Биет бус хөрөнгө	9,094,952,882.00	13,305,392,420.85
1.2.3	Биологийн хөрөнгө	3,930,000.00	10,455,000.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	123,595,964.48	125,863,679.08
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	31,426,879,394.41	39,666,462,263.24
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	42,994,251,135.04	49,040,063,023.50
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,918,108,748.73	4,109,183,748.77
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	61,915,585.50	356,649,067.21
2.1.1.4	НДШ-ийн өглөг	2,622,268.38	72,889,034.13
2.1.1.5	Хүүний өглөг		96,295,888.11
2.1.1.6	Ногдол ашгийн өглөг	146,379,171.50	146,197,187.50
2.1.1.7	Урьдчилж орсон орлого	664,637,573.56	692,919,362.08
2.1.1.8	Бусад богино хугацаат өр төлбөр	1,337,290,743.45	2,526,886,556.11
2.1.1.10	Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,130,954,091.12	8,001,020,843.91
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Бусад урт хугацаат өр төлбөр	4,370,849,753.20	4,370,849,753.20
2.1.2.20	Урт хугацаат өр төлбөрийн дүн	4,370,849,753.20	4,370,849,753.20
2.2	Өр төлбөрийн нийт дүн	8,501,803,844.32	12,371,870,597.11
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн өмч	2,449,928,700.00	2,449,928,700.00
2.3.2	Хувийн өмч	137,098,889.00	137,098,889.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	999,486,536.10	5,247,555,045.10
2.3.7	Эздийн өмчийн бусад хэсэг	8,247,270,172.39	8,247,270,172.39
2.3.8	Хуримтлагдсан ашиг	22,658,662,993.23	20,586,339,619.90
2.3.10	Эздийн өмчийн дүн	34,492,447,290.72	36,668,192,426.39
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	42,994,251,135.04	49,040,063,023.50

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	16,358,460,979.52	17,394,684,301.17
3	Борлуулалтын өртөг	13,523,394,712.77	14,343,851,233.06
4	Нийт ашиг (алдагдал)	2,835,066,266.75	3,050,833,068.11
5	Түрээсийн орлого	775,900,262.47	704,504,002.98
6	Хүүгийн орлого	282,705,625.45	149,125,182.48
7	Ногдол ашгийн орлого		
8	Эрхийн шимтгэлийн орлого		
9	Бусад орлого	572,705,901.95	487,292,708.78
10	Борлуулалт, маркетингийн зардал	1,256,556,797.18	1,153,577,454.91
11	Ерөнхий ба удирдлагын зардал	2,544,492,166.98	2,624,476,664.75
12	Санхүүгийн зардал	48,206,818.19	96,295,888.11
13	Бусад зардал	577,883,716.05	561,743,958.54
14	Гадаад валютын ханшийн зөрүүний олз / гарз	(116,069.43)	15,362,389.45
15	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз / гарз		63,090,908.27
16	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз / гарз		
17	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
18	Бусад ашиг (алдагдал)		
19	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	39,122,488.79	34,114,293.76
20	Орлогын татварын зардал	34,407,370.05	23,414,254.79
21	Татварын дараах ашиг (алдагдал)	4,715,118.74	10,700,038.97
22	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
23	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	4,715,118.74	10,700,038.97
24	Бусад дэлгэрэнгүй орлого		
25	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
26	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
27	Бусад олз (гарз)		
28	Орлогын нийт дүн	4,715,118.74	10,700,038.97
29	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,587,027,589.00	999,486,536.10	8,247,270,172.39	22,679,718,574.89	34,513,502,872.38
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
3	Залруулсан үлдэгдэл	2,587,027,589.00	999,486,536.10	8,247,270,172.39	22,679,718,574.89	34,513,502,872.38
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				4,715,118.74	4,715,118.74
5	Бусад дэлгэрэнгүй орлого					
6	Өмчид гарсан өөрчлөлт					
7	Зарласан ногдол ашиг				(25,770,700.40)	(25,770,700.40)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
9	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,587,027,589.00	999,486,536.10	8,247,270,172.39	22,658,662,993.23	34,492,447,290.72
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(2,083,023,412.30)	(2,083,023,412.30)
11	Залруулсан үлдэгдэл	2,587,027,589.00	999,486,536.10	8,247,270,172.39	20,575,639,580.93	32,409,423,878.42
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				10,700,038.97	10,700,038.97
13	Бусад дэлгэрэнгүй орлого					
14	Өмчид гарсан өөрчлөлт					
15	Зарласан ногдол ашиг					
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		4,248,068,509.00			4,248,068,509.00
17	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,587,027,589.00	5,247,555,045.10	8,247,270,172.39	20,586,339,619.90	36,668,192,426.39

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	18,608,925,278.22	22,214,907,759.64
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	16,622,130,308.69	16,385,808,286.85
1.1.2	Бусад мөнгөн орлого	1,986,794,969.53	5,829,099,472.79
1.20	Мөнгөн зарлагын дүн (-)	16,930,576,125.15	15,916,181,782.13
1.2.1	Ажиллагчдад төлсөн	5,313,320,597.97	5,595,715,573.66
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,641,485,648.74	1,562,035,284.71
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,811,903,780.69	3,170,282,874.24
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	4,509,381,009.75	2,939,341,701.41
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	261,557,451.20	353,297,320.93
1.2.6	Татварын байгууллагад төлсөн	1,602,526,082.61	945,788,489.79
1.2.7	Даатгалын төлбөрт төлсөн	1,539,900.00	34,620,582.72
1.2.8	Бусад мөнгөн зарлага	1,788,861,654.19	1,315,099,954.67
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,678,349,153.07	6,298,725,977.51
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	417,578,147.18	98,271,309.00
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		69,400,000.00
2.1.2	Бусдаас авсан зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	3,552,937.00	22,548,209.00
2.1.3	Хүлээн авсан хүүний орлого	395,886,940.49	6,323,100.00
2.1.4	Бусад орлого	18,138,269.69	
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,196,835,479.88	7,072,759,470.56
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,696,218,437.23	5,072,759,470.56
2.2.2	Бусад зарлага	500,617,042.65	2,000,000,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,779,257,332.70)	(6,974,488,161.56)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,910.20	25,792,930.83
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	5,910.20	25,792,930.83
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	25,779,736.25	25,796,432.14
3.2.1	Төлсөн ногдол ашиг	25,770,700.40	25,771,050.00
3.2.2	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	9,035.85	25,382.14
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(25,773,826.05)	(3,501.31)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(126,682,005.68)	(675,765,685.36)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,110,456,292.55	983,774,286.87
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	983,774,286.87	308,008,601.51

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2021 он гүйцэтгэл	2022 он			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
A	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт					
1	Олон улсын яриа	209,926.00	144,870.00	108,899.00	35,971.00	75.2
	Суурин утас орох яриа	46,436,413.00	43,029,442.00	41,801,989.00	1,227,453.00	97.1
	Суурин утас гарах яриа	35,476,349.00	35,066,476.00	32,097,925.00	2,968,551.00	91.5
	Зууны лавлах	178,468.00	138,103.00	127,810.00	10,293.00	92.5
	Бусад лавлах	227,209.00	273,940.00	268,535.00	5,405.00	98.0
	Суурин утас	55,897.00	54,744.00	51,081.00	3,663.00	93.3
	Интернэт	16,428.00	18,344.00	17,299.00	1,045.00	94.3
	CaTV	17,815.00	12,613.00	11,670.00	943.00	92.5
Б	Үйл ажиллагааны орлого	17,990,129,683.94	19,458,836,721.37	18,814,059,493.13	644,777,228.24	638.4
	Борлуулалтын орлого /цэвэр/	16,358,460,979.52	18,087,842,481.41	17,394,684,301.17	693,158,180.24	96.2
	Түрээсийн орлог	775,900,262.47	658,850,865.64	704,504,002.98	(45,653,137.34)	106.9
	Хүүгийн орлого	282,705,625.45	96,923,969.88	149,125,182.48	(52,201,212.60)	153.9
	Бусад орлого	572,705,901.95	541,730,997.15	487,292,708.78	54,438,288.37	90.0
	Гадаад валютын ханшийн зөрүүний олз/гарз	356,914.55	23,852,043.67	15,362,389.45	8,489,654.22	64.4
	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз/гарз	-	49,636,363.63	63,090,908.27	(13,454,544.64)	127.1
Б	Үйл ажиллагааны зардал	17,951,007,195.17	19,410,741,237.33	18,779,945,199.37	630,796,037.96	381.3
	Борлуулалтын өртөг	13,523,394,712.77	15,019,101,237.33	14,629,977,442.02	389,123,795.31	97.4
	Ерөнхий удирдлагын зардал	2,544,492,166.98	2,484,340,000.00	2,338,350,455.79	145,989,544.21	94.1
	Борлуулалт удирдлагын зардал	1,256,556,797.18	1,211,200,000.00	1,153,577,454.91	57,622,545.09	95.2
	Санхүүгийн болон бусад зардал	626,563,518.24	696,100,000.00	658,039,846.65	38,060,153.35	94.5
В	Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал	39,122,488.77	48,095,484.05	34,114,293.76	13,981,190.39	257.1
	Орлогын татварын зардал	34,407,370.05	40,000,000.00	23,414,254.79	16,585,745.21	58.5
	Татварын дараах ашиг/алдагдал	4,715,118.72	8,095,484.05	10,700,038.97	(2,604,554.92)	132.2